

Манмин Мэдээ

№ 72 2019 оны 5 сарын 26

“Тайтгарал ба амар тайван, эдгэрлийн хүч нөлөө дүүрэн байлаа”

Авралын зар хүчтэй оргилсон Венесуел, 11бчуулган нэгдлээ



Бурхан Венесуелд ивээлийн хур бороо цутган, Ариун Сүнсний хүч нөлөөг агуу ихээр илчилж өгсөнөөр Есүс Христийн сайн мэдээний гал хүчтэй дүрэлзсэн юм. 3-р сарын 12-ноос эхлэн 1н өдрийн турш Жан Жон ёон пастор (Колумби Манмин чуулганы хариуцагч, зураг 1) нь Венесуелд Здахь удаагийн авралын зар тараах үйл ажиллагаагаар дамжуулан номлогчид ажилчдын семинар, эдгэрэл ивээлийн цуглаан зэрэг 9н удаагийн цуглааныг удирдан явуулав.

Загалмай ба авралын зорилгыг тунхагласан ‘Манмин семинар’

3-р сарын 12ны өдөр Болибар муж дахь Ciudad Guayana (Сиудад Куаяна) д номлогч нар болон сүмийн үйлчлэгч нар 140гаруй хүн цугласан, 13ны өдөр Болибар мужын төв болох Ciudad Bolivar(Сиудад Болибар)-т 650хүн цугласан, 19ны өдөр Яра Куй муж San Felipe (Сан Фелип) –т 120хүн цугласан ‘Манмин семинар’ явагдсан юм (Зураг 2, 3, 7).

Семинарыг Жан Жон ёон пастор Есүс Христээр дамжуулан загалмайн авралын зорилгыг агуулсан И Жей руг тэргүүн пасторын суурь сургааль болох ‘Загалмайн үг’ лээр суурилсан хүн төрөлхтөнийг дасгалжуулсан Бурхан, Сайн мууг мэдүүлэгч жимсийг тавьсан учир, Есүс

Христ бидний аврагч болсон учрыг мэдүүлж өгсөн юм. Орлоцлогчид энэ мэт маш тодорхой ойлгомжтой бөгөөд гүн утга бүхий сургаалд ивээл аван алга ташин дэмжиж байлаа.

Дагалдах тэмдэгээр сургаалийг баталж өгсөн ‘Эдгэрэл ивээлийн цуглаан’

3-р сарын 16ны өдөр Ансотеги мужын Барселона хотод, 21-ны өдөр Тачира муж Panamericano (Панамерикано) –д И Жей руг тэргүүн пасторын залбирч өгсөн гар алчуур (Үйлс 19:11-12)-аар эдгэрлийн цуглаан явагдсан юм (Зураг 9). ‘Есүс Христ бидний аврагч болсон учир’ (Үйлс 4:12) сургаал айлдсаны дараа гар алчуураар залбирч өгсөн юм.

Үүний үр дүнд хараа сайжирч, малария өвчин, зүрхний өвчин, багтраа өвчин, нуруу нугасны өвчин зэрэг төрөл бүрийн өвчнөөс эдгэрсэн юм. Ялангуяа Josue González (Жас) босож алхаж чадахгүй байсан ба залбирал авсаны дараа төрсөнөөсөө хойш анх удаа алхдаг болж Бурхандаа алдрыг өргөлөө (Зураг 6).

Оройн нэгдсэн цуглаан хийж амийн сургаал дамжуулав.

Барселона пасторуудын холбооноос зохион байгуулсан 3-р сарын 15ны баасан гаригийн оройноос дараа өдрийн

үүрийн бцаг хүртэл 650хүн оролцсон оройн нэгдсэн цуглаан явагдаж байлаа (Зураг 4, 5). Номлогч Жан Жон ёон пастор нь залбирлын үлгэр жишээг үзүүлж өгсөн Есүсийн тухай “Залбирлын арга барил” (Лук 22:39-44) тухай сургаалийг дамжуулсан өгсөн.

Үүнээс гадна 3-р сарын 14ны өдөр Виктория чуулганд ‘Арван Минагийн зүйрлэл’, 15, 17ны өдөр Шинэ Иерусалим чуулганд тус бүр ‘Ариун байдал’ болон ‘Гадуур хувцсаа зарж илд худалдан ав’ гэсэн сургаал дамжуулсан юм (Зураг 8). Мөн 20, 22ны өдөр нийслэл Каракас хотод тус бүр номлогч нартай уулзалт хийж 12ны өдөр болон 21ны өдөр Ciudad Guayana (Сиудад Куаяна) дахь Манмин салбар танхим болон Панамерикано манмин салбар танхимын итгэгч нараа эргэж нөхөрлөсөн гайхалтай цагыг өнгөрөөсөн юм.

Түүнчлэн Венесуелд авралын зар түгээх үйл ажиллагаа нь интернэтээр И Жей руг тэргүүн пасторын сургааль ба эрх мэдэлт хүчийг мэдэрсэн Виктор Гименез итгэгчээс үүдэлтэй юм. 2018оны 7-р сарын 9ны өдөр 2ч удаа сургаал үгийг дамжуулж гар алчуураар залбирч өгсөн ба түүгээр дамжуулан энэ үйл явдлын эхлэлийг тавьсан юм.

Энэ үйл явдлаар одоогийн байдлаар нийт 11бчуулган Манмины хамтарсан сүмээр нэгдээд байна.

Венесуелийн Здахь удаагийн сайн мэдээний аялалын маршрут



Хайр бол тэвчээртэй

“Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм.
Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй.”
1 Коринт 13:4

Манмин Төв сүмийн тэргүүн пастор И Жей руг пастор

Сүүлийн үед хайр хөрж байна гэдэг үг улам биеллээ олж мэдрэгдэх болж. Олон хүмүүс хайраар цангаж, түүнийг ихэд хүсэмжлэвч, жинхэнэ хайр буюу, сүнслэг хайр юу болохыг ч мэддэггүй. Жинхэнэ хайр нь бидний үүднээс авах гэж хичээсэн ч авах боломжгүй байдаг. Тэр хайр нь юу болохыг ухаарч, зүрх сэтгэлээсээ хаяж явцад Бурханы хайр бидний сэтгэлд бууж ирэн эхлэл нь тавигддаг.

Бурхан 1 Коринт номын 13-р бүлгийн 4-7р ишлэлээр дамжуулан Сүнслэг хайр нь юу болох талаар нарийн тодорхой мэдүүлж өгсөн байдаг. Гэтэл хайр гэдэг энэ бүлэгт жинхэнэ хайрыг бүрдүүлэх хэсгүүдийн дунд ‘Тэвчээр’ гэх зүйл дутагдвал үе үе бусдыг цөхрөл гунигт унагаадаг. Нэгэн жишээгээр ажил үүрэг даатгаж өгөөд амжилт үр дүн сайн биш бол тэр ажлаа өөр хүнд өгөх явдал юм. Бусдын алдаа дутагдлаа ойлгох цаг, боломж өгөлгүй сэтгэл унаж буй тохиолдол юм.

Тэгвэл 1 Коринт номонд гардаг сүнс талын хайрыг бүрдүүлэгч 15хэсгийн дунд хамгийн түрүүнд тэвчээрийг онцолж буй учир нь юу вэ? Хайрыг бий болгоход хамгийн суурь болох шинж чанар юм. Бид Бурханы хайрыг ухаарвал тэр хайрыг эргэн тойрондоо хуваалцахын төлөө зүтгэдэг. Гэвч бусдыг хайрлаж гэж хичээх тусам харин ч эсрэгээрээ миний сэтгэл шархдах юм уу их хэмжээний гарз хохирол болон хүнд хэцүү байдал тохиолдол их байдаг.

Тэгэх тусам бусад хүн хайр хүрэм харагдах байтугай ‘Яаж ийм хүнийг хайрлаж чадах вэ!’ гэсэн бодол төрөхүйц хэмжээний ойлгомжгүй байх үе байдаг. Сүнс талаар хайрлаж гэвэл ийм хүмүүсийг ч хүртэл тэвчих хайрлах хэрэгтэй байдаг. Ямар ч учир шалтгаангүй намайг буруутгах, үзэн ядагдах, хилс байдлаар хүнд байдалд орсон өөрийн сэтгэлээ сахьж тэвчин хайрлах хэрэгтэй юм.

1. Тэвчээр бол сүнслэг хайрын эхлэл

Энэ мэт сүнслэг хайрыг бий болгохын тулд ямарч нөхцөлд тэвчиж чаддаг байх хэрэгтэй юм. Хэрэв тэсэх нь тэсдэг ч зүрх сэтгэл тавгүйтэх юм уу тэссэн ч нөхцөл байдал өөрчлөгдөхгүй санаагаар унавал яах билээ?

Нөхцөл байдал ба бусдыг буруутгахын өмнө өөрийн сэтгэлээ шалгаж ажиглах хэрэгтэй. Зүр сэтгэлээ үнэнийг үгээр өөрчилсөн бол тэвчиж чадахгүй гэж байхгүй юм. Тэсэх аргагүй байна гэдэг тэр хэмжээгээр миний сэтгэлд хорон муу байна

гэсэн үг юм.

Тэвчээр гэдэг нь хайрлахад учрах төрөл бүрийн бэрхшээл болон өөрийнхөө талаар эцсээ хүртэл тэвчинэ гэсэн үг юм. Бурханы үгэнд дуулгавартай хандан хайрлаж хэмээн зүтгэх үед ирэх бүх хүнд байдлыг тэсч тэвчих нь тэвчээрийн хайр юм.

Сүүлийн үед бусад хүн өөрийнх нь амь бие, эд хөрөнгөд нь өчүүхэн төдий хохирол учруулбал амархан заргалддаг. Тэр бусад гэх хүмүүс нь эхнэр болон нөхөр, төрүүлсэн эцэг эх, үр хүүхэд байх тохиолдол их байдаг. Бүр цаашлаад тэвчин чимээгүй өнгөрөөхөд “Тэнэг юм шиг амьдардаг, арчаагүй” гэх чичлэгдэн нэр зүүх, доромжлогддог. Гэтэл Есүс “...Харин хэн баруун хацрыг чинь алгадна, түүнд нөгөө хацраа бас тавьж өг. Хэрэв хэн нэг хүн чамтай заалдаж, цамцыг чинь авахыг хүсвэл дээлээ бас түүнд өг” (Матай 5:39-40) гэсэн байдаг.

Өөрт нь хорон мууг үйлддэг хүнд адилхан хорон муугаар нь хариу барилгүй тэвчиж өг гэсэн үг юм. Бүр цаашлаад сайнаар хариу барь гэсэн үг юм. “Томдож, тавгүйтэн, яаж тэгж чадаж байна?” бодол төрөх хэдий ч итгэл хайр байвал хичнээн л бол хийх боломжтой юм. Энэ нь цор ганц Хүү Есүсийг эвлэрлийн тахилаар зориулж өгсөн Бурханы хайрын тухай итгэл юм. Өөрийгөө ийм хайр авсан гэдэгт итгэдэг бол хичнээн том хохирол учруулсан хүнийг ч уучилж чадах юм. Загалмайн хайраар өөрийн амь биеийг ч харамгүй өгсөн Эзний хайрладаг бол яаж тэвчиж чадахгүй, хайрлаж чадахгүй байх билээ.

2. Хязгааргүй тэвчээрийг хүсдэг Бурхан

Зарим хүмүүс үзэн ядалт, уур зэрэг сэтгэл хөдлөлөө албаар дарж тэсч байгаад тодорхой хэмжээнд тулвал тэсэрдэг явдал бий. Үг дуу цөөн, гаднаа илэрхийлж чадахгүй, дотроо шаналж байгаад “Уурсах өвчин” гэх стресс сэтгэцийн гаралтай хам шинжтэй болох ч үе байна. Ийм тэвчээр нь пүршийг дарж агшааж байгаад тавивал буцаж анхны байрлалдаа очихтой адил юм.

Бурханы хүсэж буй тэвчээр нь хувиршгүй эцсээ хүртэл тэвчихийг хэлж байгаа юм. Нарийн хэлбэл тэвчиж байна гэх үг хэрэггүй хэмжээний тэвчээрийг хэлдэг. Үзэн ядалт, гоморхол зэргийг сэтгэлдээ хураах бус, тийм зүйлийг бий болгодог угийн хорон мууг хаяж, энэрэл хайраар өөрчилнө гэсэн үг юм.

Энэ мэт сэтгэлдээ хорон муугүй сүнслэг хайраар л дүүрэн бол дайснаа хүртэл хайрлана гэдэг нь

хэцүү биш төдийгүй дайсгалцах явдал ч байхгүй юм.

Сэтгэлдээ үзэн ядалт, маргалдаан, атаархал, зэргээр дүүрэн бол хичнээн сайн хүн байсан ч сул тал нь түрүүлж нүдэнд харагддаг. Яг л хар өнгийн нүдний шил зүүвэл бүх зүйл харанхуй харагддагтай адил юм. Эсрэгээрээ зүрх сэтгэлд хайраар дүүрэн бол хичнээн ойлгомжгүй хүн байсан ч хайр хүртэм харагддаг. Ямар нэг алдаа дутагдал, сул тал байлаа ч дүргүйцдэггүй. Түүнчлэн намайг үзэн ядаж, хорон муугаар хандсан түүнийг үзэн ядах сэтгэл төрөхгүй юм.

Тэвчээр нь бяцлагдсан хулсыг хугалахгүй, сүүмэлзэх дөлийг ч унтраахгүй Эзний сэтгэл юм. Сайн мэдээ тарааж байгаад чулуу шидүүлж үхэж байхдаа ч өөрийг нь чулуугаар шидэж алж байгаа хүмүүсийн төлөө зуучлан залбирал хийсэн Стефан сүмд үйлчлэгч шиг сэтгэл юм.

Нэгэн өдөр Петр Есүсээс ингэж асуудаг. “Эзэн минь ах дүү минь надад гэм хийвэл би хэдэн удаа уучлах ёстой вэ? Тудаа уучлах уу?” гэх үед Есүс “Тудаа биш 70дахин 7удаа уучил” гэж хариулсан байдаг (Матай 18:21-22). Энэ нь 70×7буюу 490удаа уучил гэсэн биш юм. 7-гийн тоо нь сүнс талаар төгс тоог илэрхийлэх учир төгс уучил гэсэн үг юм. Эндээс бид Есүсийн хайр ба уучлал нь хязгааргүй гэдгийг мэдрэх боломжтой юм.

3. Сүнслэг хайрыг бий болгох тэвчээрийн сэтгэл

Мэдээж бид бүхэн нэг өдрийн дотор үзэн ядах сэтгэлийг хайраар өөрчилнө гэдэг хэцүү. Тиймд тасралтгүй тэвчих хэрэгтэй.

Ефес 4:26 д “Уурласан ч, нүгэл бүү үйлд. Та нарын уур хилэн дээр нар бүү жаргаг” гэсэн байдаг. Эндээс уурлана гэдэг нь тэр хэмжээний итгэл өчүүхэнийг илтгэдэг. Хэдий итгэл сул дорой, уурлаж байлаа ч нар жаргатаал, өөрөөр хэлбэл тэгтлээ удаан хадгалалгүй хаяаарай гэсэн үг юм.

Сэтгэлд гүн суугдсан гэмийн шинж чанар нь Ариун Сүнсний бялхалаар гал шиг халуун залбирлаар хаягдах боломжтой юм. Үүний хамт хичнээн үзэн ядах хүн байсан ч хайрын нүдээр сайнаар үйлдэх хэрэгжүүлэх өөрийн хичээл зүтгэл зайлшгүй маш чухал юм.

Энэ мэт үйлдсээр тун удалгүй сэтгэл дэх үзэн


Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



Хаяг: Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг

Утас: 88107327, 91170773, 89737773

www.manmin.org
www.gcntv.org

ядалт арилж, бусдыг хайрлаж чаддаг болдог. Хэнтэй ч сөргөлдөх, үзэн ядах явдал байхгүй тул яг л тэнгэрийн оронд байгаа мэт аз жаргалтай амьдрах болдог (Лук 17:21).

Хүмүүс аз жаргалыг мэдрэхдээ “Тэнгэрийн оронд байгаа мэт” гэж дүрсэлдэг. Зүрх сэтгэлдээ тэнгэрийн орны орчныг бүрдүүлнэ гэдэг нь бүх худал хорон мууг хаяад сайн болон хайраар дүүрэн нөхцөл байдлыг хэлдэг. Ийм үед тэсэх тэвчих гэх явдал үгүй болж, бүгдийг хайрладаг тул үргэлж баяр хөөртэй байж чаддаг. Сэтгэлдээ

хорон муу байхгүй сайхан сэтгэлтэй байх тусам тэснэ гэдэг зүйл байдаггүй. Сүнслэг хайрыг сэтгэлдээ бий болгох тусам хүчээр тэвчих бус амар тайван дотор бусдыг өөрчлөгдөхийг хүлээж өгдөг болох юм.

Тэнгэрийн оронд зөвхөн сайн ба хайр л тэнд байдаг. Бусдыг үзэн ядах явдал ч үгүй, уурлах ч тавгүйтэх ч явдал байдаггүй. Ямар нэг сэтгэл хөдлөлөө дарж, тэвчих явдал ч байхгүй юм. Тийм болохоор хайрын үндэс болох Бурхан мэдээж тэвчинэ гэдэг зүйл байхгүй ч заавал “Хайр бол


тэвчээртэй” гэж айлдсаны учир нь хүний үүднээс энэ хайр ойлгомжтой байхад зориулагдсан үг юм.

Хайрт итгэгч та бүхэн,

Бурхан хорон мууг үйлдэгчийг хүртэл өөрчлөгдөхийг хүсэж, тэвчин хүлээж өгдөг. Ийм Бурханы хайрыг ухаарч мэдэн, тэвчин хүлээдэг сүнслэг хайрыг сэтгэлдээ бий болгон, энэ газар дээр ч төдийгүй тэнгэрийн оронд аз жаргал баяр хөөр бялхан дүүрэхийг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

‘Израйльд сайн мэдээ тараасаны 12жилийн ойг угтсан тусгай сурвалжлага’ цуврал

2019он бол сүм байгуулагдсанаас эхлэн Бурханы өгсөн алсын хараа, зорилгын дунд Израйльд сайн мэдээ тараах үйл явц бөгөөд үүний анхны алхам хийсэний 12жилийн ой тохиож байна. Тийм ч учраас Манмин мэдээ сонин цуврал тусгай сурвалжлагаар дамжуулан Бурханы удирдамжид талархан, цаашид илчлэгдэх илүү агуу гайхамшигтай зорилго биелэгдэхийг найдан хүлээж байна.



Бурханы нарийн төлөвлөж, хүн төрөлхтөнийг дасгалжуулах зорилго агуулсан газар ‘Израйль’

Бурхан хүн төрөлхтөнийг бүтээж, дасгалжуулах зорилгыг маш тодорхой харуулахын тулд Израйлийг сонгосон юм. Итгэлийн өвөг Абрахамыг босгож, түүний ач хүү Иаковыг Израйлийн арван хоёр овгийн эцэг болгож түүний үр удмынханд Бурханы хүслийг тунхагладаг.

Израйль ард түмэн Бурханы үгэнд итгэж, дуулгавартай даган, түүний хүслийн дагуу явах үед агуу үндэстэн хэмээн агуу сүр жавхланг эдэлж байсан ч, Бурханаас холдон, дуулгаваргүй болох үед эргэн тойрны улсад

эзлэгдэн боолчлогдож, дэлхий өнцөг булан бүрт дүрвэн тарж, маш их зовлон, хүнд цаг үеүдийг өнгөрөөж байлаа.

Израйль нь Есүсийн төрсөн газар бөгөөд Өөрөө авралын зар тарааж байсан нутаг хэдий ч одоо ч гэсэн аврагч Эзэнийг хүлээсээр байгаа Иудейн шашинт улс юм. Хайрын Бурхан манай сүм байгуулагдсан цагаас хойш Израйльд сайн мэдээ тараах үүргийн талаар мэдүүлж өгч, Иудей хүн байсан ч гэмшиж, эргэн эцэстээ сайн мэдээний үр дүн гарах болно гэдгийг мэдүүлж өгсөн юм.

Израйльд авралын тараах үйл ажиллагаа алба ёсоор эхлэхийг зөвшөөрсөн ‘2004 Манмин ариун аялал’

Тэгээд 1989оноос эхэлсэн ариун аялалын цаг үе болгонд Бурхан хамгийн тохиромжтой цаг агаараар хамт байсан төдийгүй, тод онгод дотор яг библейн бодит байдал дунд байгаа мэт сэтгэл хөдлөл дүүрэн байлаа.

Ялангуяа ‘2004 Манмин ариун аялал’ нь “Эзэний орон зай, ба Эзэний зүрх сэтгэлийг мэдэрч сүнсний олон мэдлэгүүлийг мэдэх болно” гэсэн ба энэ нь 2007онд болох Израйлийн нэгдсэн их цуглааныг угтсан ерөөлийн цаг байлаа.

Есүсийн үйлчлэлийн гол талбар, индэр болсон Галил

болон эргэн тойрны тосгодуудаар тойрон явмагцаа ширхэг чулуу, ширхэг өвс ургамлыг ч өнгөрөөлгүй, аялан явангаа Иерусалимд үндсэрхэг Иудейчуудийн дүр төрхнөөс Эзэний ивээлийн гэрэл хайгаад ч олдохгүй байгаа нь харамсалтай хэрэг байлаа. Гэхдээ Гэтсэмани цэцэрлэгт Есүсийн чин сэтгэлийн залбирал сонсогдох шиг Фиа Долориса дамжин загалмайд цовдлуулсан газар ба Түүний цогцсыг оршуулсан газрыг очиж үзэнгээ хайрын Бурхантай гүн холбогдох болсон юм.

Израйлийн бүх нутгаар явж сайн мэдээг тараасан ‘2007-2009 Израйльд сайн мэдээ тараах үйл ажиллагаа’

2007оны 7-р сарын 25 И Жей руг тэргүүн пастор болон сайн мэдээ тараах бүрэлдэхүүн Назарет хотоос эхлэн Израйлийн бүх нутгаар яван Есүс Христийн сайн мэдээг дамжуулж, Бурханы эрх мэдэлт хүчийг илчилж өглөө.

Энэ үйл явдал нь Израйль пасторуудын хувьд том түлхэц, дэмжлэг болж, тэд нэгдэн 2008онд ‘Кристал форум’ (Израйль пасторуудын холбоо) байгуулж, 2009оны 9-р сард Израйлийн нийслэл Иерусалимд ИСС (Олон улсын соёлын төв)-д нэгдсэн их цуглааныг явуулсан юм.

Уг нэгдсэн их цуглааны номлогч И Жей руг тэргүүн пастор нь Израйлийн нийслэл Иерусалимд бүтээгч Бурханы тухай тунхаглаж, Есүс Христ л цорын ганц Мессиа болохыг тунхаглаж, гал мэт Ариун Сүнсний нөлөөгөөр үй олон эдгэрлийн хүч нөлөө дагаддсан юм.

Христэд итгэгч хүмүүс төдийгүй үндсэрхэг Иудейчүүд хүртэл Есүс Христ тунхаглагдаж буй эцсийн үед Израйль газарт сайн мэдээний эргэлт гарах болно гэсэн зөгнөл биелэгдэх хүртэл Бурхан Өөрөө удирдаж өгсөн юм.

Ариун Сүнсний хүч нөлөөгөөр халуун болсон Кристал форум түүний гол цэг болох ‘Израйльд сайн мэдээ тараах явц’

‘2009он Израйль нэгдсэн их цуглаан’-ны дараа Израйль итгэгч нар улам эрч хүчтэй болж, магтаалын фестиваль, Гэр бүлийн семинар зэрэг төрөл бүрийн үйл ажиллагаа явуулж байна.

Израйль пасторууд И Жей руг тэргүүн пасторын залбирч өгсөн гар алчуур (Үйлс 19:11-12) аар залбирч өгөхөд гэмшил болон эдгэрлийн хүч нөлөө дагалдаж, бүр цаашлан Америк, ОХУ, Болгари, Финланд зэрэг гадаад оронд ч эдгэрлийн цуглаан зохион явуулж Ариун Сүнсний гайхамшигт хүч нөлөөг үзүүлсээр байна.

Кристал форумын номлогч нарын семинар,

Магтаалын фестиваль, Израйль улс байгуулагдсаны 70жилийн ойн үйл ажиллагаа зэрэгт манай төв сүмээс пастор болон сайн мэдээний багийг урьж оролцуулан байнгын хамтын ажиллагаатай байна. Үүнээс гадна Израйль пасторууд Манмин бүх итгэгчдийн зуны цуглаан, Манмин төв сүмийн ойн баярын үйл ажиллагаа зэрэг төрөл бүрийн үйл ажиллагаанд шууд идэвхитэй оролцож, суралцаж байгаа юм. Израйль үндэстэн бүгдээрээ Есүс Христийг хүлээн авч 7жилийн гай гамшигт унахгүй байхыг тэд чин сэтгэлээсээ хүсдэг тул ингэж идэвхитэй байна.

“Бөгтөр нуруу минь ингэж тэгширсэн”

Ким Жон чүн сүмд үйлчлэгч (71нас, Хятадын 1-р хэсэг)

Би Хятадад барилга дээр мужааны ажил хийж байгаад 2-р давхараас унаж нуруугаа хүнд гэмтээсэн юм. Түүний дараа нуруу минь бага багаар бөхийсөөр огт тэнийлгэж чадахгүй болсон юм. Үргэлж нурууны хамгаалалт зүүж, эрүүл хүмүүсийн хажууд байхдаа бөгтөр нуруунаасаа их ичдэг байлаа.

Тэгж байгаад 2003онд мөнгө хураах боломж гарч Солонгост ирсэн бөгөөд тэр үед сайн мэдээ сонссон юм. Бурхан над шиг хүний нурууг ч эдгээж өгч чадах гэсэн үгэн найдан Манмин төв сүмд ирээд үзтэл итгэгч нар маш халуун, хайраар дүүрэн, байсан ба би эхнэртэйгээ сүмд бүртгүүлсэн юм. Гэтэл миний нуруу ч дээрдсэн юм байхгүй, дараа нь бүр ажилд явж чадахаргүй болтол өвддөг болж, Хятад руу буцаж явсан юм.

2014онд Хятадад GCN телевиз (www.gcntv.org) болон Манмин мэдээ сониноор дамжуулан сүмийн мэдээ болон гэрчлэлүүдийг хүлээн авсаар эргээд нэг бодож үзсэн юм.

Дэлхий даяар ингэж олон хүн Бурханаар өвчнөө эдгээлгэж байхад яагаад би эдгэрч чадалгүй Хятад руу буцаад ирсэн юм бол? тэр л үед би “Би итгэлийн амьдралаар буруу амьдарчээ” гэдгээ ухаарч эхэлсэн юм. Одооноос яг үнэхээр сургаалийн дагуу амьдарч, И Жей руг тэргүүн пастор руу очоод залбирал эдгэрье гэсэн хүсэл тэмүүлэлтэй болсон юм.

Тэгээд 2017оны 10-р сард зээ охин маань Солонгос руу сурахаар явахад манай гэрийнхэн ч хамтдаа ирсэн юм. Би нурууныхаа төлөө 2018оны 9-р сараас эхлэн зөвхөн Бурханд найдан Манмин залбирлын холбооны эдгэрэл ивээлийн цуглаанд оролцсон юм.

Сургаал үгийг сонсох үед өмнөхөөсөө илүү шинэлэг мэдрэмжтэй байлаа. Тэгмэгцээ би дотроо “Би өнгөрсөн удаа итгэлээр амьдарч байна гэхдээ чухам юу хийж байсан бол?” гэж бодогдон маш их гэмшил харуусалд автсан юм. Нус нулимсаар дүүрэн өдөр хоног их байсан ба зарим үед Ариун Сүнсний гал дээрээ нуруу хүртэл халуу дүүгж байлаа.

Ялангуяа 2019оны 1-рсарын 2ны эдгэрэл ивээлийн цуглааны үед И Буг ним ахлагчаас гар алчуур (Үйлс 1911-12) аар залбирал авсаны дараа нуруу минь аяндаа тэнийдэг болж, өдөр хоног өнгөрөх тусам хойшоо татагдах мэт мэдрэмж төрж байлаа. Эхнэр маань ч “Нуруу нь бүрэн тэгширчээ” гэж баярлаж байлаа.



Ялангуяа 2019оны 1-р сарын 25ны өдөр Баасан гаригийн оройн мөргөлийн 2-р хэсгээр болсон 1-р сарын эдгэрэл ивээлийн цуглаанд номлогч И Сү жин пастор гал алчуурын залбирал авах үед “Нуруу бүрэн эдгэрлээ!” гэсэн итгэл болон баттай байдал мэдрэгдэж маш их баярлаж байлаа. Тэгээд гэрчилэхээр индэр рүү өгсөн гарахад гайхалтай нь өмнөхөөсөө илүү 10метр илүү хол зүйлийг маш сайн харж байлаа. Нүдний хараа хүртэл сайжирсан юм. Халлелүя!

Сүүлийн үед би үнэхээр талархаад байнга нулимстай байж, цаг л байвал библи унших зэргээр Бурханыг илүү ихээр мэдэх гэж хичээж байна. Бүх талархал ба алдрыг амьд орших Бурхандаа өргөн барья.



“Савны үрэвсэл гэхэд гайхаж байсан ч Эзэн цэвэрхэн эдгээж өгсөн”

Халиун эгч дүү (15нас, Монгол, Улаанбаатар Манмин чуулган)

2014оны 3-р сарын сүүлээр би эмээтэйгээ болон дүүтэйгээ хамт тухайн үед дахин амилалты угтсан сайн мэдээ тараах үйл ажиллагаар дамжуулан Улаанбаатар Манмин чуулганд ирэх болсон юм.

Манай эмээ (Дашцэрмаа сүмд үйлчлэгч) нь бие нь хааяа өвддөг баруун хөлөө гэмтээсэн тул таяг тулж явдаг байсан бол сүмд явж эхэлмэгц бие нь эрүүл болж, таяггүй сайн алхдаг, бүр өвдөг нугалж чаддаг болсон юм. Мөн одоо том хүний багийн удирдагчаар сүмдээ хичээнгүйлэн үйлчилж байгаа юм.

Би Глори вошип багийн гишүүний хувьд итгэмжтэйгээр үйлчлэн, аз жаргалтай итгэлийн амьдралаар амьдарч байна. Тэгж байгаад би итгэлээр өсөх том боломж үйл явдал тохиолоо. 2018оны 9-рсарын 1ны өдөр гэдэс хэвлий орчмоор бага багаар өвдөж эхэлсэн ба гэдэсний зүүн талаар хүчтэй мушгих мэт өвдсөн юм.

Эхэндээ зүгээр тэсээд өнгөрдөг байсан бол 7хоногийн дараа дахин өвдөж, өмнөхөөсөө илүү их мушгиж хатгаж өвдөн, би уйлан орон дээрээ хөрвөөж байлаа. Энэ үед эмээ маань Анхбаяр ахлагчтай утсаар холбогдон байдлыг хэлэхэд ахлагч залбирал хийж өгсөн ба тун удалгүй ахлагч манайд ирж бид хамтдаа эмнэлэг рүү явсан юм. Эмнэлэгт шинжилгээ болон рентген зураг авахуулж, түүний хариу нь зүүн талын өндгөвчний үрэвсэл гэсэн юм. Эмч надад үсэрч харайж болохгүй, дулаахан


хувцаслах ёстой гээд илүү дэлгэрэнгүй шинжилгээ хийлгээд хэвтэж эмчлүүлэх хэрэгтэй, хагалгаанд орж ч болзошгүй гэсэн ба хэрэв энэ хэвээр удвал илүү томрох аюултай гэсэн юм.

Тэгээд эмнэлэг явахын өмнө утсаар залбирал авсан өвчин багасаж, эмнэлгээс буцаж ирэх бүр өвдөхгүй болсон юм. Гэхдээ бага зэргийн хөндүүр байсан ч би дахин Анхбаяр ахлагчийн гар алчуурын залбирал авч, мөн мөргөл болгоны сургаалын дараа И Жей руг тэргүүн пасторын өвчин эдгээх залбирлыг авдаг байсан тун удалгүй манай сүмийн ойн баяр болох байсан тул манай бүжгийн баг тусгай тоглолт бэлдэж байсан ба надаас болоод тэр тоглолт болохгүй болох вий дээ маш их санаа зовж байлаа. Энэ хугацаанд манай гэр сүмээс жоохон зайтай тул хол байна гэсэн шалтгаар итгэлийн амьдралаар сайн хичээхгүй, залбирал хийдэггүй байснаа эргэн харж, түүнийгээ гэмшин Бурхандаа даатган өгсөн юм. Тэгээд манай сүмийн ойн баярын бэлтгэлдээ шамдан орсон юм.

9-р сарын 23ны өдөр ойн баярын өдөр их мөргөлийн сургаалийн дараа И Жей руг тэргүүн пасторын өвчин эдгээх залбирлыг авахад өвчин хөндүүр бүрэн арилж, бид ойн баярын тоглолтоо ч сайн дуусгаж чадсан юм. Үүнээс хойш огт өвдөөгүй бөгөөд 10-р сарын 3ны өдөр дахин шинжилгээ болон рентген зураг авахуулахад гайхалтай хариун гарсан юм. Өндгөвчний үрэвсэл бүрэн эдгэрч арилсан байлаа. Халлелүя!

Ингэж төгс эдгэрсэний 7хоногын дараа би сургуулийнхаа спортын тэмцээнд оролцож, бид багаар мөнгө медаль авч, түүнээс мөн 7хоногын дараа сургуулийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээнд манай баг тэргүүн байр эзэлж, аваргын цом, алтан медалиар шагнуулсан юм.

Одоо ээж маань ч сүмд ирдэг болсон ба ингэж амьд оршигч Бурханы хүч нөлөөг биеэр мэдэрч хариулт авсанаараа миний бие сэтгэл минь маш баяр хөөр аз жаргалтай байна. Хайраар дүүрэн Бурхан Аавдаа, Ээндээ талархаж байна. Цаашид хичээнгүйлэн зүтгэж ачийг хариулсан охин байх болно.



Залбирал авахын өмнө: Савны хананд 6х5см уйланхай харагдаж байгаа нь

Залбирал авсаны дараа: Савны хананд уйланхай харагдахгүй байгаа тухай магадлагаа

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь		
Мөргөл	Цаг	
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг	10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг	11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг	18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг	21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг	09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг	15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг	17: 00

залбирал цагийн хуваарь		
Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manmininen@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин